Б.Эрдэнэбат: Миний нээсэн аргыг Английн Төв банк дангаараа өмчлөхгүй

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор Б.Эрдэнэбаттай ярилцлаа.

-Таны бүтээлийг дэлхийн шилдэг сэтгүүлд хэвлэгдсэн гэж сонслоо. Ямар сэтгүүлд хэвлэгдсэн бэ?

-The Review of Economics and Statistics гэдэг эдийн засгийн шинжлэх ухааны сэтгүүл. Дэлхийн эдийн засгийн топ арван сэтгүүлийн нэгд ордог. Эдийн засаг судлаачдын бүтээлээ хэвлүүлэхээр мөрөөдөж явдаг сэтгүүл л дээ. Баруунд хэн нь хэн бэ гэдгийг тодорхойлдог гол үзүүлэлт нь энэ сэтгүүл болдог. Тухайн эрдэмтний судалгаа нь шинжлэх ухаандаа хүлээн зөвшөөрөгдөж байна уу гэдгийн хэмжүүр гэж ч хэлж болно. Энэ сэтгүүлд бүтээлээ хэвлүүлнэ гэдэг бол үзэл бодлоо дэлхийд сонсгож байна гэсэн үг.

-Танаас өмнө энэ сэтгүүлд монгол эрдэмтний бүтээл хэвлэгдэж байсан уу?

-Миний ойлгож байгаагаар анх удаа Монголын эрдэмтний бүтээл энэ сэтгүүлд хэвлэгдсэн. Дэлхийн эдийн засгийн шилдэг сэтгүүлүүдийн нэгд монгол эрдэмтний бүтээл хэвлэгдсэн нь нэг том ач холбогдолтой. Бид өмнө нь социалист эдийн засагтай байсан. Зах зээлийн эдийн засагтай танилцаж эхлээд хориод жил болж байна. Эдийн засгаа дөнгөж л судалж эхэлж байгаа улс. Эдийн засгийн шинжлэх ухааны хувьд монгол хүний бүтээл ийм сэтгүүлд гарна гэдэг бол том амжилт. Монголчууд тодорхой түвшинд гарсны илэрхийлэл гэж бодож байна.

-Нийтэлсэн бүтээлүүдийг нь дэлхийн шинжлэх ухааны түвшинд хүлээн зөвшөөрдөг гэхээр эрдэмтдийн бүтээлийг шалгаж оруулдаг хүмүүс нь олон улсад нэр хүндтэй эрхмүүд байдаг гэсэн үг үү?

-Дэлхийн Нобелийн шагналтнууд байна гэсэн үг л дээ. Миний бүтээлийг хэвлэсэн сэтгүүлд нэлээд хэдэн өгүүлэл хэвлүүлсэн хүн Нобель авна даа гэзэг хүлээгээд сууж байдаг. Тийм статустай сэтгүүл. Яг л спорттой адил шалгууртай. Давхар сохор шүүлтийн системээр ажилладаг. Нэг бүтээлийг хэвлүүлэхийн тулд 3-4 шүүгчид явуулдаг. Миний бүтээл хэзээ очиж шүүгдэж байгааг би мэдэхгүй. Шүүж байгаа хүн нь ямар улсын хэн гэдэг эрдэмтний бүтээлийг шүүж байгаагаа ч мэдэхгүй. Шинжлэх ухааны үүднээс зөв юм гарч байна уу, үгүй юу гэдгийг л хянадаг.

-Та энэ судалгаагаа бие дааж хийсэн үү, эсвэл сургуулийнхаа шугамаар хийсэн үү?

-Английн Төв банкнаас захиалж хийлгэсэн ажил л даа. Бидэнд ийм арга хэрэгтэй байна, гаргаад өгөөч гэж хүссэн.

-Бүтээл чинь ямар сэдэвтэй вэ?

-"Олон улсын инфляцийн динамик дахь бүтцийн өөрчлөлт" гэсэн сэдэвтэй. Судалгааны ажил маань хоёр хэсэгтэй. Нэг нь онолын. Нөгөө нь хэрэглээнийх. Хэрэглээний хэсэгт нь Их долоо, Европын холбооны улсуудын инфляцийг авч үзсэн. Онолын хэсэгт нь эдийн засгийн шинжлэх ухаанд шинэ арга зохиож нэвтрүүлснээ хийсэн. Аливаа юм хоорондоо динамик холбоотой. Энэ холбоо зарим тохиолдолд өөрчлөгдөнө, хэзээ, ямар хэмжээгээр өөрчлөгдсөнийг нь мэдэх арга байгаагүй. Өөрөөр хэлбэл өөрчлөлт байгаа эсэхийг нь шалгаж, хэзээ, хэдий хэмжээгээр өөрчлөгдсөнийг нь тодорхойлох арга зүй байгаагүй. Тэр аргыг нь гаргаж ирсэн.

-Арай энгийнээр тайлбарлаач, жишээ нь таны онцолсон инцляци дээр гэхэд энэ аргыг яаж хэрэглэнэ гэсэн үг вэ?

-Улс бүр төв банктай. Төв банкууд нь мөнгөний бодлого хэрэгжүүлдэг. Тэд инфляцийг нам дор, тогтвортой түвшинд барихыг хүсдэг. Энэ бодлогоо тодорхой хэмжээгээр мөнгөний бодлого, мөнгөний хэрэгслүүдээрээ дамжуулж хэрэгжүүлж таарна аа даа. Тэгж хэрэгжүүлэхэд бусад улсын мөнгөний талаар хэрэгжүүлж байгаа бодлого тухайн улсад ямар нөлөөтэйг харах ёстой гэсэн үг. Манай улсын хувьд гэхэд Хятадын Төв банк мөнгөний ямар бодлого хэрэгжүүлж байна, тэр бодлого нь Монголд яаж нөлөөлж байна вэ гэдгийг эхлэхэд тооцох хэрэгтэй. Ингэснийхээ дараа ямар бодлого барихаа тогтоох шаардлагатай болж байгаа юм. Даяаршил хүчтэй хөгжөөгүй үед улс бүр бараа бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэх, хэрэглэдэг байлаа. Харин одоо глобалчлал хүчтэй илэрч, дэлхийн улс орнууд бие биенээсээ хамааралтай, уялдаа холбоотой болсон. Жишээ нь инфляци өслөө гэхэд дотоод шалтгаан нь хэд, гадаад нөлөө нь хэдэн хувь гэдгийг тогтоох шаардлагатай болчихож байгаа юм.

-Ер нь ямар ч асуудлыг ярьсан даяаршлын нөлөө анзаарагддаг л даа. Таны нээсэн шинэ аргыг инфляциас өөр зүйлд, бүр цаашлуулбал өөр салбарт ашиглаж болох уу?

-Энэ бол ерөнхий арга зүй. Макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүдэд ашиглаж болно. Тухайлбал ингэж ашиглаж болно гэж инфляциар жишээ татсан юм л даа. Яг энэ арга зүйг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, ажилгүйдлийн түвшин дээр ч ашиглаж болно. Заавал эдийн засаг ч биш, бусад шинжлэх ухаанд ч ашиглаж болох арга.

-Английн төв банк захиалагч гэдэг утгаараа энэ аргыг өмчлөх эрхийг нь бас авсан уу, эсвэл бид ч хэрэгжүүлэх боломжтой юу?

-Шинжлэх ухааны топ сэтгүүлд хэвлэгдсэн ажлуд дэлхий нийтээр тардаг л даа. Энэ аргыг Английн Төв банк дангаараа өмчлөхгүй. Судлаачид Review of Economics and Statistics сэтгүүлд өгүүллээ гаргахдаа хэрэглэх арга зүй, программ хангамжийг нь мөн өгчихдег. Сэтгүүлийн зүгээс бидний аргыг сонирхсон хүнд тэр материалыг 10 ам.доллараар зардаг. Тэгэхээр мөнгийг нь төлсөн хэн ч бидний гаргаж ирсэн арга зүйг авч болно гэсэн үг.

-Сонирхсон хүн танаас авч болох уу?

-Болно.

-Таны дэвшүүлсэн аргыг Монгол руу хөрвүүлэхэд шууд ашиглах боломжтой юу?

-Тийм боломж бий.

-Төв банкнаас энэ аргыг инфляци дээр яаж ашиглахыг яг Монголынхоо хувьд гаргаад ирэхэд гэсэн санал ирвэл та зөвшөөрөх үү?

-Дуртайя хийж өгнө. Гэхдээ судалгааны ийм ажлыг зүгээр л нэг өдөр суугаад хийчихдэггүй. Тодорхой хугацаа, хөдөлмөр, хөрөнгө шаарддаг. Английн төв банкны захиалгаар хийсэн тэр бүтээл гэхэд бараг дөрөв, таван жил шаардсан. Ийм удаан хугацаанд дөрвөн хүн зэрэг нухаж байж тийм хэмжээний судалгаа гаргадаг.

-Монголынхоо инфляцийг мэдэж сонирхож хардаг байх?

-Одооноос харж эхэлж байна. Судалгааны ажлууд хийж эхэлж байгаа.

-Манай хувьд инфляци өсдөг нь жам, тайлбар шалтгаан нь ч бараг уламжлалт гэмээр болчихсон. Шатахууны өсөлт, махны үнийн хөөрөгдөл, бэлэн мөнгө тараалтаас болж инфляци өсдөг гэж нийтээрээ ойлгодог. Ер нь инфляци ямар шалтгаанаар өсөөд байна вэ?

-Гүйлгээн дэх мөнгөний хэмжээг нэмэхээр инфляци өсдөг. Энэ бол эдийн засгийн сууль хэдэн баримтын нэг. Мөнгө хэвлэгдэ байх юм бол юмны үнэ өсөх нь тодорхой. Монголын инфляцийн шалтгаан эндээс хамаарч байгаа байх. Яг тэдэн хувиар хамаарч байгаа гэсэн судалгааны дүн алга. Бусад улсын туршлага, бидний мэдэж байгаа эдийн засгийн онолын үүднээс харахад гарцаагүй тийм нөлөө ажиглагдаад байна. 2010, 2011 онд нэг их наад төгрөгийг Хүний хөгжил сангаас тараасан эсэхийг нь шалгаж, хэзээ, хэдий хэмжээгээр өөрчлөгдөнийг нь тодорхойлох арга зүй байгаагүй. Тэр аргыг нь гаргаж ирсэн.

Миний бүтээлийг хэвлэсэн сэтгүүлд нэлээд хэдэн өгүүлэл хэвлүүлсэн хүн нобель авна даа гэзэд хүлээгээд сууж байдаг. Тийм статустай сэтгүүл. Яг л спорттой адил шалгууртай. Давхар сохор шүүлтийн системээр ажилладаг. Нэг бүтээлийг хэвлүүлэхийн тулд 3-4 шүүгчид явуулдаг. Миний бүтээл хэзээ очиж шүүгдэж байгааг би мэдэхгүй. Шүүж байгаа хүн нь ямар улсын хэн гэдэг эрдэмтний бүтээлийг шүүж байгаагаа ч мэдэхгүй.

-Инфляци гэдэг томъёолол иргэдийн хувьд таньдаг хэрнээ таньдаггүй үг шиг санагддаг. Өсчихөөрөө л халаас хоослоод байдаг айхтар эд гэж ойлгодог. Инфляцийг энгийнээр тодорхойлбол?

-3000 төгрөгөөр авч байсан махны үнэ 4000, 5000, 6000 төгрөг болж өсөөд байгаг л инфляци гэзэд байгаа юм. Инфляци орлого багатай хүмүүст хамгийн хүнд тусдаг. Инфляци ерөнхийдөө хүнсний бүтээгдэхүүнүүдээр дамжиж Монголд орж ирж байна. Монголын ядуу хүмүүсийн нийт орлогын бараг 60-70 хувь нь хүнсэнд явж байна. Гэтэл өндөр орлоготой хүмүүсийн хувьд инфляци маш бага хэмжээгээр тусдаг. Учир нь тэр хүмүүс хувийн хэрэглээндээ Монгол Улсын эдийн засгаас харьцангуй бага зүйл ашигладаг. Гадаадад зугаална, гадаадаас өндөр үнэтэй машин авна, гадаадад шоппинг хийнэ. Тэр хэрэглээнийх нь үнэ тэгж их өсөөд байдаггүй.

-Инфляцид нөлөөлдөг нэг зүйл бол шатахууны үнэ. Таныг энэ талаар судалгаа хийж байгаа гэж сонссон?

-Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос захиалга өгч хийлгэж байгаа ажлын нэг нь л дээ. Газрын тосны бүтээгдэхүүний үнэ Монголын эдийн засгийн үзүүлэлтүүдэд яаж нөлөөлдөг талаар судалгаа хийж байна. Үр дүн нь энэ сарын дундуур гарах байх. Одоогоор инфляцид ийм зүйлүүд нөлөөлдөг гэж яриж байгаа ч яг тэрийг нь шинжлэх ухааны үндэстэй нотолж, тэдэн хувиар нөлөөлж байна гэж гаргаж ирсэн юм алга.

-Шатахууны үнэ нэмэгдэнгүүт хүнсний үнэ дагаад өсчихдег. Гэсэн хэрнээ дараа нь шатахууны үнэ буусан ч доошилдоггүй. Шатахууны үнийг заавал өргөн хэрэглээний барааны үнэд нөлөөлөхөөр хэмжээнд өсгөөд байгаагийн цаад шалтгаан нь юу байна аа?

-Ер нь хүчээр л буулгадаггүй юм бол үнэ доошоо буух маш дургүй. Нефтийн үнэ дэлхийн зах зээлийн хаяанд, ОХУ-ын дотоод зах зээл гэзэд тодорхой шалтгаануудаас болж байнга өөрчлөгддег. Гэтэл дотоодоос жижиглэнгийн үнээ тогтмол барь гэзэд шаардчихдаг. Ус урсаж байхад чөлөөтэй урсуулахгүй хаалт хийгээд байвал эцэстээ яах вэ. Адагдал нь хуримтлагдаж байгаад нэг өсөхдөө сад тавих нь ойлгомжтой. Харин гадаад шалтгаануудыг харгалзаж гурав, таван төгрөгөөр бага багаар нэмж, бууруулж, үнийн уян хатан байдлаар хандвал гэнэт 300 төгрөгөөр нэмэх явдал гарахгүй. Инфляцид ч тэгж их нөлөөлөхгүй. Зохицуулалт огт хэрэггүй гэсэн үг биш л дээ. Гэхдээ хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж арай уян хатан байлгах ёстой болов уу.

-Инфляцийн хувьд үлгэр авмаар, сайн бодлого барьж байгаа ямар улс байна?

-Дэлхийн практикийг харахаар Төв банкуудынх нь гол зорилго бол инфляцийг аль болох бага түвшинд тогтвортой байлгах. Бүгд ингэж бодож ажиллаж байна. Монгол банкны хувьд ч инфляцийг аль болох барья, инфляцийг онилъё гэсэн бодлого барьж байх шиг байна. Гэхдээ Монголбанкинд нэг тодорхой бус зүйл бий. Монгол банкны тухай хуулинд төгрөгийн тогтвортой байдлыг хангана гэсэн заалт байдаг. Энэ заалтыг хүмүүс хоёр утгаар хардаг. Нэг нь доллартай харьцах төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, нөгөө нь инфляцийг тогтвортой барих гэж ойлгодог. Олон улсын практик бол дотоодын худалдан авах чадварыг буюу инфляцийг барих чиг рүү хандаж байна. Амжилттай явж байгаа нэг улс бол Турк. Сүүлийн үед нэлээд сайжирсан. Европын холбоо, Америкт "Бид та нарын хичээлийг сайн сурлаа. Гэхдээ та нар өөрсдийнхөө заасан хичээлийг бидэн шиг сайн хэрэгжүүлээгүй юм байна" гэж хэлэхээр түвшинд хүрчихлээ л дээ.

-Эдийн засгийн хөгжил эдийн засагч бэлддэг тогтолцооноосоо шалтгаалаад байгаа юм биш үү?

-Шуудхан хэлэхэд ичгүүртэй л юм болоод байгаа юм. Монголд хамгийн олноор бэлтгэгдэж байгаа мэргэжлийн нэг бол эдийн засагч. Тэгэхээр эдийн засагчдаа яаж бэлдэж байгаагаа харах л хэрэгтэй. Сүүлийн үед гарч ирж байгаа залуус ерөнхийдөө гадаадад явж юм үзэж дуулсан хүмүүс байна. Монгол Улсын эдийн засагч бэлдэж байгаа боловсролын тогтолцоо сайн биш. Дөрвөн жилд хэрэгтэй, хэрэггүй 40-50 хичээл заадаг. Ийм нөхцөлд нэг хичээлийг маш өнгөц үзэхээс аргагүй л дээ. Юу ч мэдэхгүй, гэсэн хэрнээ аймаар өргөн хүрээний баахан юм сонсчихсон хүмүүс эдийн засагчаар төгсдег. Баруунд бакалаврын зэрэг авахад 16, 18 хичээл л үздэг. Нэг хичээлийг үзэхдэз онолоос нь эхлэхэд практикт яаж хэрэгэлдгийг нь хүртэл зааж өгдөг. Энэ чиг рүү л явмаар санагддаг.

Ц.БААСАНСҮРЭН